



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/12 БУА-2018/8/СТА-ОИТС Мандалговь хот

Төлбөр барагдуулах тухай






Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар төсөл хэрэгжүүлэгч 13 иргэн гэрээнд заасны дагуу үндсэн зээл, зээлийн хүүг төлөлгүй хугацаа хэтрүүлснээс нийт 47,929,921 / дөчин долоон сая есөн зуун хорин есөн мянга есөн зуун хорин нэгэн / төгрөгийн авлагыг зээлдэгч нар төлөөгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Иргэний тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.4.-т /Хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгэгч нь түүнд ямар нэг тохиолдол нөлөөлсөн эсэхийг харгалзахгүйгээр хохирлыг хариуцна/, 222.5.-т /Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй./, зээлдүүлэгчтэй байгуулсан “Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээ”-ний 2.2-т /Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж, дуусгана. /Хавсралт-1// гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.7-д /Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн нийт 47,929,921 / дөчин долоон сая есөн зуун хорин есөн мянга есөн зуун хорин нэгэн / төгрөгийн зээлийн авлагыг нэр бүхий 13 зээлдэгч /Хавсралт 1/ нараар нөхөн төлүүлж, Дэлгэрцогт сумын Сум хөгжүүлэх сангийн Төрийн сан банк дахь 100080155406 дугаар дансанд 2018 оны 5 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх.

Актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга Иш-Ёндон, нягтлан бодогч Б.Ууганцэрэн, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Ө.Дугармаа нарт хариуцуулав.

<p>ТОГТООСОН:</p> <p>АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН</p> <p>4817144213 ЗКА00039 9033475</p>	<p>АКТЫГ</p> <p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>ЗАСАГ ДАРГА  Б.ИШ-ЁНДОН</p> <p>НЯГТЛАН БОДОГЧ  Б.УУГАНЦЭРЭН</p> <p>СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН  Ө.ДУГАРМАА</p> <p>ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН </p>
--	---

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын 2018 оны 02 дугаар сарын 14
өдрийн 01/12 дугаар төлбөрийн актын
хавсралт

4817144213
ЗЮА0039 9033475

**Дэлгэрцогт сумын сум хөгжүүлэх сангийн хугацаа
хэтрэлттэй зээлтэй иргэдийн жагсаалт**

№	Зээлдэгчийн нэрс	Он	Аудит-үлдэгдэл		
			Зээл	Хүү	Нийт
1	Дэгжин загвар		500,000.00	100,000.00	600,000.00
2	Д.Мөнх-эрдэнэ <РД:Зю75092358>	2012	1,713,906.00	584,831.00	2,298,737.00
3	Пү.Бат-эрдэнэ <РД:зе85052915>	2014	9,423,407.00	1,599,293.00	11,022,700.00
4	Т.Батсайхан <РД:зе87082111>	2014	3,774,126.00	533,198.00	4,307,324.00
5	Д. Шихихутаг <РД:зю87030473>	2015	8,575,892.00	617,421.00	9,193,313.00
6	Х.Ууганбаатар <РД:зе 90112715>	2015	6,755,261.00	549,757.00	7,305,018.00
7	О.Мяасүрэн <РД:ДЮ95122613>	2015	8,706,393.00	997,491.00	9,703,884.00
8	Л.Төрмандах	2001	152,200.00	55,000.00	207,200.00
9	Ж.Оюунбадам		250,000.00	125,000.00	375,000.00
10	Н.Батсайхан		300,000.00	150,000.00	450,000.00
11	Д.Гаваа		100,000.00	51,000.00	151,000.00
12	Б.Наранчимэг	2014	1,981,620.00	214,125.00	2,195,745.00
13	Ю.Дашдаваа		-	120,000.00	120,000.00
	Дүн		42,232,805.00	5,697,116.00	47,929,921.00

БЭЛТГЭСЭН АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН НЯГТЛАН БОДОГЧ

Б.УУГАНЦЭРЭН

4817144213
ЗЮА0039 9033475